



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

20 ~~20~~ оны 11 сарын 09 өдөр

Дугаар 0/624

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 317 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 218 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм”-ийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн БУТ-2014-024 дугаар гэрээт Есөнбулаг сумын ЭМШУИС-ийн харьяа аймаг дахь Анагаах ухааны сургуулийн 960 суудалтай сургуулийн болон спорт заалны барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор
Нарийн бичгийн дарга:	Г.Бат-Эрдэнэ	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хяналтын инженер
Гишүүдэд:	М.Мандаххүү	-аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга
	Ж.Мөнхчимэг	-аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн газрын харилцаа, барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
	Б.Амарзаяа	-Барилгын хөгжлийн төвийн Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн ахлах инженер
	Ж.Лхамаа	-Барилгын хөгжлийн төвийн Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер
	Б.Хатанболд	-Барилгын хөгжлийн төвийн Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер

2.

- Ц.Амарсанаа -Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч
- Б.Лхагва-Очир -Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн
- О.Мөнхбаатар -Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч
- Д.Даваасамбуу -Мэргэжлийн хяналтын газрын Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч
- Д.Отгонжаргал -Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч
- Б.Балдорж -Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Н.Энхтуяа -Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын барилга, хөрөнгө оруулалт, сууц өмчлөгчдийн холбоо хариуцсан мэргэжилтэн
- Д.Цэвэлмаа -"Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер
- Б.Бээжин -"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер
- С.Дарамдад -"Мандал-Голомт" ХХК-ийн дулааны шугам сүлжээний инженер
- Д.Байгальмаа -"Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын ашиглалтын инженер
- Ш.Ариунаа -Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны аймгийн зөвлөл
- М.Банзаагаяа -аймаг дахь Анагаах ухааны сургуулийн захирал
- Ц.Ганболд -"Жи Эй Икс" ХХК-ийн захирал
- М.Батмөнх -"Манхан-Уст" ХХК-ийн захирал
- Б.Чинбат -"Манхан-Уст" ХХК-ийн ерөнхий инженер

2.Барилгын угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа техникийн нөхцөл, зураг төсөв, ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сайтад байршуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгах, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг аймаг дахь Анагаах ухааны сургуулийн захирал (М.Банзаагаяа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ

